

БАТЛАВ
 СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
 ДАРГА **М. ИДЭРБАТ**
 2025 оны 02 сарын 07 өдөр

**СҮХБААТАР АЙМГИЙН 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2025 оны 02 дугаар сарын 07

Баруун-Урт

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэгч байгууллага
<i>Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</i>				
1.1.	Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх	-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; -Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх; -Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд	
1.2.	Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	-Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; -Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; -Үр дүнг тооцсон байх.	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд	
1.3.	Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном, гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах	-Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; -Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; -Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд	
1.4.	Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон	-Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; -Авлигын мэдээлэх 110	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд	

	авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	дугаарын утсыг сурталчилсан байх; -Олон нийтэд түгээсэн байх.	
<i>Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх</i>			
2.1.	Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	-2025 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх; -Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах; -Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх.	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд
2.2	Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх	-Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; -Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; -Иргэд, олон нийтээс байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд
2.3.	Өөрийн байгууллагын албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт, АТГ-ын дүгнэлт зэрэг нээлттэй мэдээллийн хуульд заасан журмын дагуу тогтмол байршуулах	-Хуульд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ил тод байршуулсан мэдээллийн эзлэх хувь	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд
<i>Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах</i>			
3.1.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг	-Цахимаар үзүүлж буй үйлчилгээний төрөл, тоо, үйлчилгээ авсан иргэдийн тоо	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд

	дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах		
3.2.	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр албан хаагчид, иргэдэд сургалт зохион байгуулах	-Байгууллагын албан хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр болон авлига, ашиг сонирхлын зөрчилд хүлээлгэх хариуцлагын талаар сургалтад жилд 2-оос доошгүй удаа хамруулсан байх;	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд
3.3	Авлигатай тэмцэх газрын зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдлийн хэрэгжилтийг зохион байгуулах, хариу мэдэгдэх	-Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, мэдэгдлийг бүртгэлжүүлэх; -Хугацаанд нь хариуг хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдлийн эзлэх хувь;	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд
3.4	Удирдах албан тушаалтнуудад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, зөвлөмж өгөх	-Нэгдсэн болон салбарын зөвлөгөөн, уулзалт зохион байгуулж, мэдээлэл хүргэсэн байх;	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд
3.5	Сум, агентлагийн ЭБАТ-ны үйл ажиллагаа, мэдүүлэг гаргах үйл ажиллагаанд хяналт тавих	-Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэсгийн удирдамжид тусгаж, хяналт тавьж, үр дүнг тооцсон байх; -Зөвлөгөө, зөвлөмж өгсөн байх;	Аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлагууд, байгууллагууд
3.6	Сургагч багш бэлтгэх, үйл ажиллагааг идэвхжүүлэх	-АТГ-аас зохион байгуулдаг сургагч багш бэлтгэх сургалтад 1 албан хаагчийг хамруулах, -Сургагч багш нарын зохион байгуулсан арга хэмжээний тоо	Аймгийн ЗДТГ,

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: ЭБАТ
ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Б.НАРАНЦЭЦЭГ
П.МӨНХЖАРГАЛ

БАТЛАВ
 СУХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
 Д.САНДУГ
 ДЭДЭР
 ТИМОНХЖАРГАЛ

**СУХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2025 оны 02 дугаар сарын 07

Баруун-Урт

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах эзэн
<i>Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</i>						
1.1.	Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сүвгүүд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, ө/бусад сурталчилж, олон нийтэд хүргэх	-Контент түгээх сүвгийн тоо, -Түгээсэн контентийн тоо, -Давтамж	4, 17,	4, 20, 1000	Жилийн турш	Хэвлэл мэдээллийн тасал, ЭБАТ
1.2.	Иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	-Өдөрлөгт оролцсон иргэдийн тоо, -Санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь -Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай үйлдсэн эсэх	-, -,	-50, -90%, -Тийм	5-р сард	ТЗУХ Ахлах Мэргэжилтэн, Өргөдөл гомдол Хариуцсан Мэргэжилтэн, ЭБАТ